



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 477

Улаанбаатар хот

“Буянт-Ухаа спортын ордон”
төрийн өмчит үйлдвэрийн газрын
зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын
жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, ажиллагсдын ажил үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг оновчтой хуваарилах шаардлагаар зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

- 1.1. Захиргаа, санхүүгийн алба;
- 1.2. Техникийн алба;
- 1.3. Нийтлэг үйлчилгээний алба.

2. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын албан тушаалын жагсаалтыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг захирал Л.Энхбаярт даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаар, дүрмийг шинэчлэн батлах тухай” 18 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

0002309

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
44 дугаар тогтоолын хавсралт



**"БУЯНТ-УХАА СПОРТЫН ОРДОН" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

Д/д	Албан тушаал	Орон тоо
1	Захирал	1
	Захиргаа, санхүүгийн алба	
2	Албаны дарга	1
3	Маркетингийн менежер	1
4	Борлуулалтын менежер	2
5	Нарийн бичиг, хүний нөөцийн мэргэжилтэн	1
6	Ерөнхий нягтлан бодогч	1
7	Аж ахуйн нярав	1
	Техникийн алба	
8	Албаны дарга	1
9	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн	1
10	Дулаан хангамжийн техникч	1
11	Дуу гэрэлтүүлэг, мэдээллийн технологийн техникч	2
12	Цахилгааны техникч	2
13	Сантехникч	2
	Нийтлэг үйлчилгээний алба	
14	Албаны дарга	1
15	Үйлчилгээний ажилтан	3
16	Үйлчлэгч	8
17	Мужаан	1
	НИЙТ	30